БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
# ТУШААЛ

2025 оны 06 сарын 04 өдөр Дугаар А/42 Өлгий

## ГЭДЭСНИЙ ХАЛДВАРТ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ, СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТУХАЙ

Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөө батлах тухай” А/528 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Журам, заавар шинэчлэн батлах тухай” 328 дугаар тушаал, 2018 оны “Заавар батлах тухай” А/528 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Гэдэсний халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг эрчимжүүлэх 3 сарын аяны удирдамж, төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Гэдэсний халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг хүн амын дунд үр дүнтэй, өргөн цар хүрээтэй явуулахыг харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Гэдэсний халдварт өвчин, хоол хүнсээр дамжих халдварт өвчнөөс сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах, үйл ажиллагаанд дүгнэлт хийн байгууллагын удирдлагад танилцуулахыг халдварт өвчний урьдчилан сэргийлэлт, тандалт голомтын ариутгал, халдваргүйтгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн (А. Нургүл)-д үүрэг болгосугай.

4.Хоол хүнсээр дамжих халдварт өвчнөөс сэргийлэх талаар ард иргэдэд өргөнөөр сурталчлахыг хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн (Т.Рахат)-д нарт үүрэг болгосугай.

5.Сургалт зохион байгуулах, сурталчилгааны материал хэвлүүлэх төсвийг халдварт өвчний хөтөлбөрийн дотоод урсгалын санхүүжилтээс гаргахыг Эрүүл мэндийн газрын нягтлан бодогч (С.Еншигүл)-д зөвшөөрсүгэй.

6.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн ахлах мэргэжилтэн (Х.Арай)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.ДАУЫРЖАН

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны .6..дугээр сарын 4... өдрийн
А/72..тушаалын ........1......... хавсралт

## ГЭДЭСНИЙ ХАЛДВАРТ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ, СЭРГИЙЛЭХ 3 САРЫН АЯНЫ УДИРДАМЖ

### ҮНДЭСЛЭЛ

Улсын хэмжээнд сүүлийн 10 жилд (2014-2024 он) хоолны хордлогот халдварын нийт 126 дэгдэлт бүртгэгдэж нийт 6536 хүн өвдсөн ба 1858 хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн байна. Тус дэгдэлтийн 30.9% хүүхдийн байгууллагад, 43.6% ААН байгууллага, ресторан, нийтийн хоолны газарт 9.5% уул уурхайн байгууллагад тус тус бүртгэгдсэн байна. Хүүхдийн байгууллагад ялангуяа сургуулийн үдийн хоол хөтөлбөрийн хүрээнд олгож буй хоол хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой хоолны хордлого хүүхдийн байгууллагын хоолны хордлогын 30.7%-ийг эзлэж байна. 2024 онд нийт 21 удаагийн дэгдэлт бүртгэгдэж нийт 1108 хүн өртөж, 470 хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн байна.

Манай аймгийн хэмжээнд 2025 оны эхний 5 сарын байдлаар цусан суулга 1, хоолны хордлого 65, гар хөл, амны өвчин 28, сальмонеллёзын халдвар 10 тохиолдол тус тус бүртгэгдэж, гэдэсний халдвар цаашид нэмэгдэх хандлагатай байна.

Иймд урин дулааны улиралд аялал зугаалга, хөдөө, хот руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөн ихэсдэг, мөн гудамж, талбайд ил задгай хүнсний бүтээгдэхүүнийг ихээр худалдаалдагтай холбоотой хоол хүнсээр дамжих халдварын эрсдэл эрс нэмэгддэг тул болдог гэдэсний халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

### ЗОРИЛГО:

Гэдэсний халдварт өвчин, хоол хүнсээр дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх

### ЗОРИЛТ:

1. Гэдэсний халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг эрчимжүүлэх
2. Гэдэсний халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг эрчимжүүлэх 3 сарын аяныг зохион байгуулах
3. Гэдэсний халдварт өвчний тоог бууруулах

**Хамрах хүрээ:** Эрүүл мэндийн газар, Харьяа эрүүл мэндийн байгууллагууд

**Зохион байгуулагч:** Эрүүл мэндийн газар

**Гарах үр дүн:**

1. Гэдэсний халдварт өвчний тоог бууруулна.
2. Ард иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилнэ.
3. Гэдэсний халдварт өвчний хариу арга хэмжээ сайжирна.
4. Эмч эмнэлгийн ажилтнуудад эрүүл мэндийн боловсрол дээшилнэ.

ХУГАЦАА: 2025.06.02-09.02 хүртэлх хугацаанд явагдана.

ХЯНАСАН: НЭМХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Х. АРАЙ

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН: ХАЛДВАРТ ӨВЧНИЙ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ, ТАНДАЛТ ГОЛОМТЫН АРИУТГАЛ, ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН А. НУРГҮЛ

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны ..6..дүгээр сарын ..4.. өдрийн
А/42 тушаалын ........2........ хавсралт

# ГЭДЭСНИЙ ХАЛДВАРТ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ, СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2022.06.02

| № | Үйл ажиллагаа | Хугацаа | Хариуцах эзэн | Хамтран ажиллах мэргэжилтэн |
|---|---|---|---|---|
| 1 | Гэдэсний халдварт өвчин, хоол хүнсээр дамжих хордлогот өвчнийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх | 2025.06.02-05 | Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Харьяа эрүүл мэндийн байгууллагууд | ЭМГ-ын мэргэжилтэн А. Нургүл |
| 2 | Гэдэсний халдварт өвчитэй тэмцэх, сэргийлэх ажлыг эрчимжүүлэх өдөрлөг зохион байгуулах, гэдэсний халдварт өвчин, хоол хүнсээр дамжих хордлогот халдвараас урьдчилан сэргийлэх талаар гарын авлага тараах | 2025.06.09-20 | Нэгдсэн эмнэлэг, Харьяа эрүүл мэндийн байгууллагууд | ЭМГ-ын мэргэжилтэн А. Нургүл, Т. Рахат нар |
| | Халдварт, ариутгалын тасгийн үйл ажиллагааг сурталчлах, рийл хийх | 2025.06.12 2025.06.23 | Нэгдсэн эмнэлэг | ЭМГ-ын мэргэжилтэн А. Нургүл, |
| 3 | Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болох Дербес ТВ, орон олон нийтийн радиогоор гэдэсний халдварт өвчин, хоолны хордлогоос урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөөг 7 хоног бүр 2-оос доошгүй нэвтрүүлэх, рийл, гарын авлага гаргах | 2025.06.02-07.02 | Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Харьяа эрүүл мэндийн байгууллагууд | ЭМГ-ын мэргэжилтэн А. Нургүл, Т. Рахат нар |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5 | Халдварт өвчний голомтын ариутгал, халдваргүйтгэлийн бодисын зааварчилгааны талаарх харьяа эрүүл мэндийн байгуулллагуудад цахим хурал зохион байгуулах | 2025.06.16 | Эрүүл мэндийн газар, ЗӨСТ, Нэгдсэн эмнэлэг | ЭМГ-ын мэргэжилтэн А. Нургүл Нэгдсэн эмнэлгийн халдвар судлаач Е.Жанбота |
| 6 | Сургууль, цэцэрлэгийн эмч, арга зүйч, нийгмийн ажилтан, нарт гэдэсний халдварт өвчин, хоол хүнсээр дамжих хордлогот халдвараас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулж, мэргэжлийн арга зүйгээр хангах | 2025.05.01-06.15 | Эрүүл мэндийн газар, Харьяа эрүүл мэндийн байгууллагууд | ЭМГ-ын мэргэжилтэн А. Нургүл, Т. Рахат нар |
| 7 | Аймгийн хэмжээний хоол, хурим найр үйлчилгээний газар, хүнсний дэлгэрүүдэд хяналт шалгалт хийж, илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч ажиллах | 2025.06.02-09.02 | Эрүүл мэндийн газар, | ЭМГ-ын ЭАХХ-ын улсын байцаагч Ж. Галия |
| 8 | Аймгийн хэмжээний хоол, хурим найр үйлчилгээний газар, хүнсний дэлгэрүүдэд гэдэсний халдварт өвчин, хоол хүнсээр дамжих хордлогот халдвараас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулж, мэргэжлийн арга зүйгээр хангах, зөвлөмж хүргүүлэх | 2025.06.02-09.02 | Эрүүл мэндийн газар, Харьяа эрүүл мэндийн байгууллагууд | ЭМГ-ын мэргэжилтэн Т. Рахат |
| 9 | Сургууль, цэцэрлэгүүдэд гар угаах нөхцөл боломжийг бүрдүүлсэн эсэх, гал тогоонд ариун цэврийн дүрмийн шаардлагыг хэрэгжүүлж, хүнсний аюулгүй байдлыг ханган ажилласан эсэхэд хяналт тавих | 2025.06.02-09.02 | Эрүүл мэндийн газар | ЭМГ-ын ЭАХХ-ын улсын байцаагч Б. Гүлбану |
| 10 | Нэгдсэн эмнэлгийн тасаг, нэгжүүдийг хамруулан | 2025.06.09- | Харьяа эрүүл мэндийн | ЭМГ-ын мэргэжилтэн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | гэдэсний халдварт өвчнөөс сэргийлэх талаар хэвтэн эмчлүүлэгсдэд сургалт хийх | 2025.07.09 | байгууллагууд | А. Нургүл |
| | Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасаг, амбулаторийн хэсэгт өдөрлөг зохион байгуулах | 2025.06.09<br><br>2025.06.20 | Нэгдсэн эмнэлэг | ЭМГ-ын мэргэжилтэн А. Нургүл |
| 11 | Үйл ажиллагааны явцын тайланг нэгтгэж сар 01-ний өдөр<br><br>asnurgul@bo.moh.gov.mn цахим хаягаар баримтжуулалттай хамт ирүүлэх | 2025.07.01-09.02 | Нэгдсэн эмнэлэг, Харьяа эрүүл мэндийн байгууллагууд | ЭМГ-ын мэргэжилтэн А. Нургүл |

ХЯНАСАН: НЭМХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Х. АРАЙ

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН: ХАЛДВАРТ ӨВЧНИЙ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ, ТАНДАЛТ ГОЛОМТЫН АРИУТГАЛ, ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН А. НУРГҮЛ

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 6 дугээр сарын 4 өдрийн
01/42 тушаалын 3 хавсралт

**“ГЭДЭСНИЙ ХАЛДВАРТ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ, СЭРГИЙЛЭХ САРЫН АЯН”-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДЛАГАТАЙ САНХҮҮЖИЛТИЙН ТООЦОО**

| № | Задлын төрөл | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ | Хариуцах байгуулага |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Гэдэсний халдвараас сэргийлэх стенк/Хөлтэй самбар/ | ш | 1 | 80.000 | 80.000 | |
| 2 | Хоолны хордлогоос сэргийлэх стенк/хөлтэй самбар/ | ш | 1 | 80.000 | 80.000 | |
| 3 | Ариутгагч нарт хийх сургалтын цайны зардал | ш | 35 | 5000 | 175 000 | |
| 4 | Нийт | | | | **335.000** | |

Хянасан:

ЭМГ-ын ня-бо С.Еншигүл

Тооцоо судалгаа гаргасан:

ЭМГ-ын Халдварт өвчний урьдчилан сэргийлэлт, тандалт голомтын ариутгал, халдваргүйтгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн А.Нургүл

Эрүүл мэндийн газрын даргын

2025 оны ...6...дүгээр сарын ..4.. өдрийн

А/42 тушаалын ........5........ хавсралт

# “ГЭДЭСНИЙ ХАЛДВАРТ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ, СЭРГИЙЛЭХ САРЫН АЯН”-НЫ ХҮРЭЭНД “ТИРЛИК” ЗАХАД СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА ХИЙХ БАГУУДЫН ХУВААРЬ

2025.06.02

| № | Худалдаа, үйлчилгээний нэр, төрөл | Сургалт, сурталчилгаа хийх үйл ажиллагааны сэдэв | Хугацаа | Хариуцах эзэн |
|---|---|---|---|---|
| 1 | Хүнсний бүтээгдэхүүний худалдааны дэлгүүрүүд | 1. Гэдэсний халдварт өвчин, хоол хүнсээр дамжих хордлогот халдвараас урьдчилан сэргийлэх талаар МСС хийх<br>2. Гарын авлага тараах, зөвөлгөө өгөх<br>3. Дербес зурагтаар сурталчлах | 2025.06.09 | Жансая ӨЭМТ-ийн НЭМА |
| 2 | Мах, махан бүтээгдэхүүний худалдааны хэсгүүд | | 2025.06.10 | Мейрим ӨЭМТ-ийн НЭМА |
| 3 | Жимс, ногооны худалдааны хэсгүүд | | 2025.06.11 | Шипагер ӨЭМТ-ийн НЭМА |
| 4 | Ил задгай сүү, сүүн, гурил,гурилан бүтээгдэхүүн, будаа худалдааны хэсгүүд | | 2025.06.12 | Раушан ӨЭМТ-ийн НЭМА |

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН: ХАЛДВАРТ ӨВЧНИЙ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ, ТАНДАЛТ ГОЛОМТЫН АРИУТГАЛ, ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН А. НУРГҮЛ

Эрүүл мэндийн газрын даргын

2025 оны 6 дугээр сарын 4 өдрийн

А/142 тушаалын 5 хавсралт

# ОРОН НУТГИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛЭЭР ГЭДЭСНИЙ ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ САРЫН АЯНЫ ХҮРЭЭНД МЭДЭЭЛЭЛ СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА ХИЙХ БАЙГУУЛЛАГУУДЫН ХУВААРЬ

2025.06.02

| № | Байгууллага | Хариуцах эзэн | Сэдэв | Он,сар, өдөр |
|---|---|---|---|---|
| 1 | Эрүүл мэндийн газар | Халдварт өвчний урьдчилан сэргийлэлт, тандалт голомтын ариутгал, халдваргүйтгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн А. Нургүл<br>Утас: 99426186 | Гэдэсний халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх | 2025.06.02 |
| 2 | Шипагер ӨЭМТ | НЭМА Б. Лида<br>Утас: 99312141 | Цусан суулга өвчнөөс урьдчилан сэргийлэх,зөвлөмж | 2025.06.06 |
| 3 | Эрүүл мэндийн газар | Хоол тэжээлийн аюулгүй байдал мэргэжилтэн ажилтан Т.Рахат<br>Утас:95573535 | Хоол, хүнсний аюулгүй байдал анхаарах асуудал | 2025.06.09 |
| 4 | Жансая ӨЭМТ | НЭМА Ербагда<br>Утас: 94301331 | Гар, хөл амны өвчнөөс урьдчилан сэргийлэх | 2025.06.12 |
| 5 | Нэгдсэн эмнэлэг | Нэгдсэн эмнэлгийн халдвартын их эмч Б. Ахерке<br>Утас: 99663690 | Гэдэсний халдварт өвчний төрлүүд, халдвар дамжих зам, илрэх шинж тэмдэг, оношилгоо | 2025.06.16 |
| 6 | Раушан ӨЭМТ | НЭМА Сулушаш<br>Утас: 85930703 | Аюулгүй хоол хүнсний 5 түлхүүр | 2025.06.19 |
| 7 | Нэгдсэн эмнэлэг | Нэгдсэн эмнэлгийн халдвар судлаач Е.Жанбота<br>Утас: 99419731 | А вируст гепатит өвчин, урьдчилан сэргийлэх аргууд | 2025.06.23 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8 | Мейрим | НЭМА Ж. Сунхар Утас: 99425056 | Гэдэсний халдварт өвчин, хөрсний бохирдлоос сэргийлье | 2025.06.26 |
| 9 | Эрүүл мэндийн газар | ЭАХХХ-ын улсын байцаагч Ж. Галия Утас: 99926414 | Хоолны хордлогоос урьдчилан сэргийлэх, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалыг хангаж ажиллах | 2025.07.02 |
| 10 | Нэгдсэн эмнэлэг | НЭ-ийн хүүхдийн тасгийн эрхлэгч Е. Гафу Утас: 94111202 | Хүүхдийн дунд тохиолддог гэдэсний халдварт өвчний эмнэлзүй,оношилгоо | 2025.07.07 |
| 11 | Шипагер ӨЭМТ | НЭМА Б. Лида Утас: 99312141 | Салхинцэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх | 2025.07.17 |
| 12 | Жансая ӨЭМТ | НЭМА Ербагда Утас: 94301331 | Цусан суулга өвчнөөс урьдчилан сэргийлэх,зөвлөмж | 2025.07.21 |
| 13 | Нэгдсэн эмнэлэг | Нэгдсэн эмнэлгийн халдвар судлаач Н.Алемгүл Утас: 99670066 | Халдварт өвчний голомтын ариутгал, халдваргүйтгэлийн ач холбогдол | 2025.07.31 |
| 14 | Раушан ӨЭМТ | НЭМА Сулушаш Утас: 85930703 | Гар, хөл амны өвчнөөс урьдчилан сэргийлэх | 2025.08.04 |
| 15 | Мейрим | НЭМА Ж. Сунхар Утас: 99425056 | Гэдэсний халдварт өвчин, хөрсний бохирдлоос сэргийлье | 2025.08.14 |
| 16 | Эрүүл мэндийн газар | ЭАХХХ-ын улсын байцаагч Б.Гүлбану Утас: 99425481 | Хоолны хордлогоос урьдчилан сэргийлэх, сургууль, цэцэрлэгийн гал тогооны халдвар хамгаалал анхаарах асуудал | 2025.08.21 |